



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Цэцэрлэгийн багш, арга зүйчдийн
сургалт семинар явуулах тухай

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хууль, Засгийн газрын 2005 оны 246, 2009 оны 05 дугаар тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2013 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн цэцэрлэгийн хүүхдийн бие бялдрын хөгжилтийн түвшинг шалгах ажлыг эрчимжүүлэх, багш, арга зүйчдийн ур чадварыг дээшлүүлэх “Хөгжим-Хөдөлгөөн-Хөгжил” сэдэвт сургалт, семинарыг 2013 оны 01 дүгээр сарын 14-19 өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсугай.

2. Сургалт, семинарыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, хичээл заах багш нарын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт, семинарт шаардагдах 2.010.000 /хоёр сая арван мянган/ төгрөгийг нийслэлийн орон нутгийн төсвийн сургалт, семинарын зардлаас гаргахыг ня-бо Ж.Цэдэнсодномд зөвшөөрсүгэй.


4. Сургалт, семинарыг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2013 оны сарын-ны өдрийн
..... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт




Цэцэрлэгийн багш, арга зүйчдийн
сургалт семинар төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Багшийн ажлын хөлс: 5 хоног х 40 цаг х 20.000 төг	800.000 төг
2.	Заалны хөлс:	400.000 төг
3.	Бичиг хэргийн зардал:	100.000 төг
4.	Гарын авлага, сурталчилгаа:	300.000 төг
5.	Видео бичлэг, зураг, хальс угаалах	300.000 төг
6.	Сертификат хэвлүүлэх	110.000 төг
ДҮН:		2.010.000

Боловсруулсан
Хянасан

А.Болдмаа
Ж.Цэдэнсодном

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2013 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн
...А/03... тушаалын хоёрдугаар хавсралт



Цэцэрлэгийн багш, арга зүйчдийн сургалт семинар
хичээл заах багш нарын бүрэлдэхүүн

- | | |
|------------------|--|
| 1. А.Болдмаа | НБТСГазрын ахлах мэргэжилтэн |
| 2. Т.Эрдэнэчимэг | Сургуулийн өмнөх боловсролын сургуулийн багш |
| 3. Ц.Март | Монголын Гимнастикийн холбооны зөвлөх багш |
| 4. Д.Эрдэнэчимэг | НЭМУ-ний төвийн ЭМ-ийн сургалт судалгааны
төвийн захирал |
| 5. Д.Энхчимэг | Сэтгэцийн эрүүл мэндийн үндсэний төвийн 9-р
тасгийн эрхлэгч |
| 6. П.Оюунбилэг | Хийн дасгалын уламжлагч багш, доктор,
профессор |
| 7. Б.Номин | МУБИС-ийн БТДС-ийн багш |
| 8. Ж.Чулуунцэцэг | Хан-Уул дүүргийн 34-р сургуулийн биеийн
тамирын багш |
| 9. А.Болорцэцэг | БГД-ийн зөвлөх багш |